



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014-07-08

Улаанбаатар хот

Дугаар 127

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирддагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 "г", Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 18/18 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс тогтоох нь:

1. Монголын наадамын цогцолбор хүй долоо хутаг олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахад мөрдөх журмыг нэгдүгээр хавсралтаар, арга хэмжээ зохион байгуулахад мөрдөх үнэ тарифыг хоёрдугаар хавсралтаар баталсугай
2. Олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахад мөрдөх журам, үнэ тарифыг мөрдүүлж ажиллахыг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Э.Бат-Үүл/-д үүрэг болгосугай

ДАРГА

Д.БАТТУЛГА

Хавсралт

**МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОРТ ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН
БАЙГУУЛАХАД МӨРДӨХ ЖУРАМ**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын

Тэргүүлэгчдийн 2014 оны 07 дугаар сарын 08 ний өдрийн 127 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь "МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР" Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын (цаашид "МНЦ" гэх) нутаг дэвсгэрт иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, худалдаа үйлчилгээ эрхлэх болон олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахад үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Журмыг "МНЦ" ОНӨТҮГ-ын Хүй долоон худагт худалдаа үйлчилгээ эрхлэх, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах иргэд, аж ахуйн нэгж, байгууллага дагаж мөрдөнө.

1.3 Журмыг хэрэгжүүлэх ажлыг "МНЦ" ОНӨТҮГ -ын захиргаа зохион байгуулж, Нийслэл, дүүргийн мэргэжлийн хяналтын газар, хэлтэстэй хамтран хяналт тавьж ажиллана.

1.4. "МНЦ" ОНӨТҮГ нь дүрмийнхээ 3.2-т заасан үйл ажиллагаа зохион байгуулахдаа Төрийн ёслолын алба, Улсын баяр наадмын комисс, баяр наадмын тохижилт, засвар, худалдаа үйлчилгээний салбар хороо, Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл ОНӨААТҮГ, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газар, Худалдаа үйлчилгээний хэлтэс, Цагдаагийн ерөнхий газар болон холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллана.

1.5. Хүй долоон худагт худалдаа үйлчилгээ эрхлэх зорилгоор талбай түрээслэх, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах иргэд, аж ахуйн нэгж, байгууллага Нийслэлийн худалдаа үйлчилгээний нийтлэг журмын холбогдох заалтуудын шаардлагын дагуу болзлоо хангаж "МНЦ" ОНӨТҮГ -ын даргатай гэрээ байгуулсны үндсэн дээр үйл ажиллагаа явуулна.

Хоёр. "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ -ын эрх, үүрэг

2.1. "МНЦ" ОНӨТҮГ нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн баталсан 2013 оны 09 сарын 04-ний 99 дугаар тогтоолыг үндэслэн төлбөрт үйлчилгээний хөлс, үнэ тарифын дагуу талбай, зогсоол ашиглалт, түрээсийн болон бусад үйлчилгээний төлбөр тооцоог дансанд төвлөрүүлнэ.

2.2. Хүй долоон худагт олон нийтийн арга хэмжээ зохион байгуулж, худалдаа үйлчилгээ эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг цахилгаан эрчим хүч, усаар хангах, ариун цэврийн өрөө ажиллуулах, хуваарийн дагуу хог ачилт хийх зэрэг үйлчилгээг гэрээнд заасны дагуу үзүүлнэ.

2.3. Хүй долоон худагт зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний үеэр иргэдийн тав тухтай эрүүл, аюулгүй байдлыг хангах зорилгоор цагдаагийн постууд гаргаж, эмнэлгийн анхан шатны түргэн тусламж үзүүлэх цэгүүд ажиллуулна.

2.4. Худалдаа үйлчилгээний цэгүүд, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолууд болон явах чиглэл, цагдаагийн постууд, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх цэгүүдийн байршлын талаарх мэдээллийг самбарт харагдахуйц байдлаар тавьж байршуулна.

Гурав. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын эрх үүрэг

- 3.1. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас "МНЦ" ОНӨТҮГ -ын барилга, байгууламж, автозам, тоног төхөөрөмж зэрэг өмч хөрөнгөнд хохирол учруулсан бол хохирлыг хуульд заасны дагуу барагдуулна.
- 3.2. Хүй долоон худагт худалдаа үйлчилгээ эрхлэх, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах иргэд, аж ахуйн нэгж, байгууллага нь Нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журамд заасан ариун цэвэр, эрүүл ахуй, тоног төхөөрөмж техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааны стандарт шаардлагуудыг бүрэн хангасны үндсэн дээр "МНЦ" ОНӨТҮГ -ын даргатай гэрээ байгуулж ажиллана.
- 3.3. Гэрээнд тухайн арга хэмжээний эхлэх, дуусах цагийн хуваарь, талуудын хүлээх үүрэг хариуцлага болон эрхийг тодорхой заасан байна.
- 3.4. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага нь "МНЦ" ОНӨТҮГ-ын захиргаатай байгуулсан гэрээнд заасан үйлчилгээний төлбөр болон талбай ашиглах түрээсийн төлбөрийг төлж баримтыг ахлах нягтлан бодогчид өгснөөр үйл ажиллагаа эрхлэх эрх нь нээгдэнэ.
- 3.5. Хүй долоон худагт худалдаа үйлчилгээ эрхлэх, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах иргэд, аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, стандартууд, Хүй долоон худагт нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан дүрэм, журам, төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан шийдвэрийг дагаж мөрдөнө.
- 3.6. Хүй долоон худагт худалдаа үйлчилгээ эрхэлж буй болон олон нийтийн арга хэмжээ, баяр наадам зохион байгуулж байгаа иргэд, аж ахуйн нэгж, байгууллага нь хүрээлэн буй орчныхоо цэвэрлэгээ болон тохижилтыг хариуцан өөрийн нэр хаяг, дугаарыг монгол хэлээр харагдахуйц байршуулсан байна.
- 3.7. Хүй долоон худагт худалдаа үйлчилгээ эрхэлж буй болон олон нийтийн арга хэмжээ, баяр наадам зохион байгуулж байгаа иргэд, аж ахуйн нэгж байгууллага нь хэрэглэгчдэд соёлч боловсон үйлчилж, өөрийн байгаа орчныг тохижуулж, хэв журмын зөрчилгүй ажиллана.
- 3.8. Гэрээ байгуулаагүй болон зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулах, тогтоосон цэгээс өөр газар буух, Тамхины хяналтын тухай хуулийг зөрчиж олон нийтийн газар тамхи татах, олон нийтийн газар архидан согтуурах, дуу чимээ ихтэй, хурц үнэртэй үйлдвэрлэл явуулах, Эрүүл ахуйн шаардлага хангаагүй үйлчилгээ ажиллуулах, ил задгай хог хаягдал хаяхыг хориглоно.

Дөрөв. Хүлээлгэх хариуцлага

- 4.1. Энэхүү журмыг зөрчих, олон нийтийн өмчийг эвдэж гэмтээх, үйл ажиллагаандаа үйлчилгээний соёл, зан харьцааны доголдол гаргах, хэрэглэгчийн эрүүл мэндэд хохирол учруулах зэргээр бусдын эрх ашгийг хохироосон бол "МНЦ" ОНӨТҮГ нь байгуулсан гэрээгээ цуцалж тухайн аж ахуйн нэгжийн талаар холбогдох байгууллагад хандаж хууль тогтоомжид заасны дагуу арга хэмжээ авна.
- 4.2. Талууд хамтран ажиллах явцад маргаан үүссэн тохиолдолд хуулийн дагуу шүүхээр шийдвэрлэнэ.

Хавсралт

Монгол наадам цогцолборын Хүй долоон худагт олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахад мөрдөх үнэ тариф

Монгол наадам цогцолборын Хүй долоон худагт олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахад мөрдөх үнэ тариф

№		
Үйлчилгээний нэр төрөл		
Хэмжих нэгж		
Үнэ тариф		
1.		
Баяр наадам, бусад арга хэмжээ		
Энгэрийн тэмдэг хаяг		
1 ширхэг		
3000		
Үзэгчдийн суудлын түрээс		
1 бүр		
3000		
Ариутгалын хураамж		
м2		
600		
2.		
Хог хаягдлын хураамж		
Аж ахуй нэгж байгууллага		
1 өдөр		
1500		
Түргэн үйлчилгээний цэг		
1 өдөр		
2500		
Сүүдрэвчтэй худалдаа		
1 өдөр		
1500		
Уяачид		
1 өдөр		
2500		
Бусад жижиг худалдаа		
1 өдөр		
1500		
Хоолны газрын үйлчилгээ		
1 өдөр		
2500		
3.		
Цахилгааны хураамж		
Төрөл бүрийн ахуйн хөргөгч		
тус бүр		
4000		
Төрөл бүрийн ус буцалгагч, будаа агшаагч		
тус бүр		
4000		
Төрөл бүрийн үйлчилгээний хөргөгч		
тус бүр		
7000		
Халуун тогоо		
тус бүр		
4000		
Цахилгаан зуух/Плитка/		
тус бүр		
4000		
Шарах шүүгээ		
тус бүр		
4000		
Телевизор, хөгжим		
тус бүр		
4000		
Компьютер, принтер		
тус бүр		
4000		
Тайзны гэрэлтүүлэг чимэглэл		
иж бүрдэл		
5000		
Гэрэл		
тус бүр		
1000		
380В-ын төрөл бүрийн	цахилгаан хэрэгсэл	
тус бүр		
15000		
Төрөл бүрийн хүүхдийн цахилгаанаар		ажилладаг тоглоом
тус бүр		

Хавсралт

3000

Хуушуурын тогоо

тус бүр

6000

4.

Нийтийн бие засах газар

Контейнер ОО

1 хун

200

Зөөврийн ОО

1 хун

200

Модон ОО

1 хун

200

5.

Наадмын талбайг ашигласны төлбөр хураамж

Гэр /1 өдөр/

тус бүр

20000

Майхан /1 өдөр/

тус бүр

8000

Асар /1 өдөр/

тус бүр

10000

6.

Сурталчил

-гааны самбарын хураамж

Сурталчилгааны самбар /улиралд/

1м2

80000